



Save the Children

САНАЛ БОЛГОЖ БУЙ ОЛОН
ЗОРИУЛАЛТААР АШИГЛАГДАХ
ЗАГВАР ДОТУУР БАЙР

ЗАГВАР №1 2018 он 3-р сар

ЗАГВАР ДОТУУР БАЙР САНАЛ БОЛГОХ ҮНДЭСЛЭЛ

2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 517 дотуур байранд 35 мянга гаруй хүүхэд амьдарч байгаагаас 70 орчим хувь нь малчны хүүхдүүд байна. Бага, дунд, ахлах ангид суралцдаг эдгээр хүүхдүүд жилийн 224-245 хоног буюу есөн сарын турш эцэг эх, гэр бүлээсээ хол дотуур байранд амьдарч, боловсрол эзэмшиж байгаа юм. Тэд эрүүл ахуйн нөхцөл хангасан, сурч хөгжих боломж бүрдсэн орчинд амьдрах, өсөж торних, хөгжих ёстой. Гэвч хүүхэд бүрт ээлтэй дотуур байрны орчин бий болгоход саад болж байгаа цөөнгүй хүчин зүйл байна. Тухайлбал:

2008-2009 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, 6 настай сургуульд элсүүлэх болсоноор шинэ ангиуд бий болж, сургууль, дотуур байрны хүчин чадал, багтаамжийг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ бий болжээ.

Одоо ашиглаж байгаа дотуур байрнуудын 74 хувь нь 1990 оноос өмнө баригдсан буюу барилгын насжилт өндөр, ашиглалтын хугацаа дууссан, түүнчлэн зориулалтын бус барилга байгууламж ашиглагдаж байгаа зэргээс зарим сумдад дотуур байр хүрэлцэхгүй байна

6 настай хүүхдийг сургуульд элсүүлж эхлэснээр дотуур байранд 6-8 настай хүүхдүүдэд тохирсон орчин нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай болсон юм. Түүнчлэн дотуур байрны орчинг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд (улсын хэмжээнд 750 орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дотуур байранд амьдарч байна) ээлтэй хэлбэрээр тохижуулах шаардлагатай байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд зөвхөн аймгийн төв дээр байрладаг бөгөөд сумын ЕБС-н сурагчид мэргэжлийн дадлага хийх боломж хязгаарлагдмал байдгаас хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй байгаа төрөл бүрийн мэргэжилтэй танилцаж, мэргэжлээ сонгох боломж дутмаг байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр Монгол улсын Засгийн Газар ихээхэн анхаарч байгаа боловч аймаг сумдын түвшинд жуулчдыг хүлээн авах байр, дэд бүтэц дутагдалтай байсаар байна.

Хүүхдийг Ивээх Сан дээрх асуудлуудыг шийдэхэд дэм болж, дотуур байранд хүүхдийн амьдрах эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх үүднээс дотуур байрны энэхүү шинэлэг загварыг таньд санал болгож байна.

Төс баримт эх сурвалж:

Хүүхдийг Ивээх Сан, БСШУСЯ, “Сургуулийн дотуур байрны орчин нөхцөл, хүүхдийн хөгжил хамгааллын өнөөгийн байдал” 2017 судалгаа Норвегийн Тусламжийн Байгууллага





Save the Children




ЗАГВАР ДОТУУР БАЙРНЫ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Энэхүү загвар дотуур байр нь аймаг, сумын төвүүдэд нэг маягаар баригдах боломжтой ба ерөнхий боловсролын сургуулийн 6-18 насны 150 хүүхдийн багтаамжтай. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх үүднээс хүүхэд хөгжлийн төв бүхий хичээллэх танхим, номын сан, урлаг спортын олон зориулалтаар ашиглагдах заал, цайны газар, эмнэлгийн хэсгүүдийг цогц байдлаар төлөвлөсөн бөгөөд дараах давуу талуудтай:

- 7 блокоос бүрдэх тус загвар дотуур байр нь тухайн орон нутгийн хүн амын нягтрал, хэрэгцээ шаардлагад тулгуурлан хэсэгчлэн барих боломжтой ба ингэснээр эдийн засаг, төсвийн хувьд хэмнэлттэй байх боломжтой юм.
- Уг барилгыг Монгол улсад мөрдөгдөж буй норм дүрмийг баримтлан орчин үеийн дэвшилтэт технологи, хийц элемент, материал ашигласанаар дулаан алдагдал багатай, нар, салхины сэргээгдэх эрчим хүч ашиглаж гэрэлтүүлэг, агаар сэлгэлтэд нэмэлт эрчим хүч шаардагдахгүй байхаар төлөвлөсөн.
- Жигүүрийн 6 блок нь гол орц буюу Хүүхэд Хөгжлийн Төв хэсэгтэй шууд холбогдох ба блок тус бүр онцгой байдлын үед шууд гарах аврах гарц, бие даасан ариун цэврийн байгууламжтайгаар төлөвлөгдсөн.
- Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх үүднээс уг **ЗАГВАР ДОТУУР БАЙР** нь хүүхэд хөгжлийн төв бүхий хичээллэх танхим, номын сан, урлаг спортын олон зориулалтаар ашиглагдах заал, цайны газар, эмнэлгийн хэсгүүдийг цогц байдлаар төлөвлөсөн.
- Хүүхэд хамгаалагдах эрхээр бүрэн хангагдсан ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний асран хамгаалагч нарт ээлтэй орчин бүрдүүлсэн.
- Хүүхэд хөгжлийн төвөөр дамжин хүүхэд зөв боловсон өсч торних орчинг бүрдүүлсэн.
- Хүүхдийн тав тухтай амьдрах орчин байж тэдний эцэг эх хүүхдүүдээ эргэн ирэхэд хамтдаа байх нөхцөлийг бүрдүүлсэн.
- Ахлах ангийн сурагчид ажил мэргэжлийн баримжаа олгох онол практикийн сургалтанд хамрагдах боломжтой.
- Түүнчлэн суманд зохиогдох бусад спорт, урлаг соёл, үзэсгэлэн худалдаа гэх мэт олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахад ашиглах боломжтой байх юм.




ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ



Д/д	ТОДОРХОЙЛОЛТ	ТАЙЛБАР	ДАВХРЫН ТОО
1	Хүүхэд хөгжлийн төв	төлөвлөж буй	2 давхар
2	Урлаг спортын заал	төлөвлөж буй	1 давхар
3	Цайны газар	төлөвлөж буй	1 давхар
4	А блок	төлөвлөж буй	2 давхар
5	В блок	төлөвлөж буй	2 давхар
6	С блок	төлөвлөж буй	2 давхар
7	Д блок	төлөвлөж буй	2 давхар

ТАНИХ ТЭМДЭГ


-  Төлөвлөж буй барилга, байгууламж
-  Төлөвлөж буй авто зам, талбай
-  Авто зогсоол
-  Явган хүний зам
-  Төлөвлөгдөж буй ногоон байгууламж
-  Төлөвлөж буй амрах талбай бүхий сандал
-  Төлөвлөж буй сандал
-  Төлөвлөж буй гэрэлтүүлэг
-  Төлөвлөж буй түр цугларах талбай
-  Төлөвлөж буй хог ангилан хаях цэг
-  Төлөвлөж буй гол орц
-  Төлөвлөж буй эмнэлгийн зориулалттай орц
-  Төлөвлөж буй сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж
-  Төлөвлөж буй сургалтын бааз
-  Хүлэмж
-  Салхин сэнс



Гол орц ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТӨВ

Гол орц ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТӨВ-д хүүхдийн тав тухтай орчинд сурч боловсрох, ая тухтай амьдрах нөхцлийг бүрэн хангах зорилготойгоор хичээллэх танхим, номын сан, амралтын болон төрөл бүрийн тоглоомын өрөө, эмнэлгийн хэсэг зэргийг төлөвлөсөн.





- **НОМЫН САН**-д Ерөнхий боловсролын хичээлийн ном, уран зохиол, сонгодог уран зохиол болон бүх төрлийн номын фонд байрлана
- Дотуур байрны хүүхдүүдийн хичээл хийх орчин нөхцлийг хангасан бие дааж суух орчин болон уншлагын ширээнүүдтэй
- **ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ӨРӨӨ** нь хүүхдүүд ой тогтоолт, хөгжөөнт тоглоом, үндэсний тоглоом наадгайгаар тоглох
- Үүдний хэсгээр тэргэнцэртэй хүмүүс орж гарах налуу шаттай, блок тус бүр тусгаарлах хаалга, аюулгүйн камерийн системээр бүрэн тоноглогдсон
- Эвакуац буюу галын гарц болон эмчийн үзлэгийн өрөөтэй шууд холбогдож хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангасан
- Мөн орон нутгийн иргэдэд үйлчлэх боломжтой



ОЛОН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ УРЛАГ СПОРТЫН ЗААЛ

Хүүхэд хөгжлийн төвтэй шууд холбогдсон олон зориулалтаар ашиглагдах УРЛАГ, СПОРТЫН ЗААЛ-ыг нэг блок болгон төлөвлөсөн бөгөөд уг заалыг дотуур байрны хүүхдүүдээс гадна сум орон нутгийн иргэдэд үйлчлэх боломжтой байдлаар үндсэн гол орцноос тусдаа орц болон ариун цэврийн өрөө, бусад шаардлагатай хувцасны өлгүүр, дэлгүүртэйгээр төлөвлөсөн




- Хүүхдийн эрүүл чийрэг бие, дасгал хөдөлгөөн биеийн тамирын хичээл сургалт орох, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх
- Урлаг соёлын арга хэмжээ, тэмцээн уралдаан
- Илтгэл, хурал цуглаан
- Мөн орон нутгийн иргэдэд үйлчлэх бусад арга хэмжээг зохион байгуулах боломжтой



ЦАЙНЫ ГАЗАР РЕСТОРАН

Хүүхэд хөгжлийн төвтэй шууд холбогдсон ЦАЙНЫ ГАЗАР-ыг нэг блок болгон төлөвлөсөн бөгөөд уг заалыг дотуур байрны хүүхдүүдээс гадна сум орон нутгийн иргэдэд үйлчлэх боломжтой байдлаар үндсэн гол орцноос тусдаа орц болон ариун цэврийн өрөө, бусад шаардлагатай хувцасны өлгүүр, дэлгүүртэйгээр төлөвлөсөн


- Дотуур байрны хүүхдүүдийг эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангах
- Нийтийн хоолны стандартад нийцсэн гал тогоо, агуулах, цэвэр бохирын хэсэгтэй
- Хүнс, хүнсний бүтээгдэхүүнийг гаднаас бохирдолгүй оруулах орцтой
- Хоол хийхэд гарсан үнэр, уур чийгийг гадагшлуулах агааржуулалтын системтэй
- Хооллох танхимыг олон зориулалтаар ашиглах боломжтой /найр, хурим, хүлээн авалт/ байдлаар төлөвлөсөн.



А блок: 6-8 настай хүүхдүүд, тэдний асран хамгаалагчдад зориулсан гэр бүлийн 8 өрөө

ОЛОН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАГДАХ ЗАГВАР ДОТУУР БАЙР-ны А блокыг 6-8 настай хүүхдүүд, тэдний асран хамгаалагчдад зориулсан гэр бүлийн 8 өрөөтэй байхаар төлөвлөсөн.


- А блок нь Хүүхэд хөгжлийн төвөөс тусгаарлах хэсэгт соронзон цоож бүхий шилэн хаалттай амралтын хэсэгтэй
- Өрөө бүр хүүхдийн эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх бөгөөд тус бүр ариун цэврийн өрөө, гал тогооны хэсэгтэй
- Хичээл хийх орчин нөхцөл бүрдсэн хичээлийн ширээ, номын тавиуртай
- Байгалийн гэрэлтүүлэг хангалттай тусах цэлгэр уужим цонх, дуу чимээ тусгаарлах хаалга зэргийг төлөвлөсөн
- Өрөөний хана, таазыг угааж цэвэрлэх боломжтой эмульсэн будгаар будах бөгөөд шаардлагатай үед өнгө сэргээхэд урсгал зардал багатай байдгаараа давуу талтай
- Өрөө тасалгааны шалыг шахмал PVC хулдаасаар хийх ба уг хулдаас нь чанар эдэлгээний хувьд ломинат, паркетэн шалнаас үнийн хувьд ижил боловч эдэлгээ удаан, арчилж цэвэрлэхэд хялбар байдлаараа давуу талтай.



В блок: 9-өөс дээш насны охидод зориулсан 10 өрөө

ОЛОН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАГДАХ ЗАГВАР ДОТУУР БАЙР-ны В блокыг 9-өөс дээш насны Охидод зориулсан 2 төрлийн 10 өрөөтэй байхаар төлөвлөсөн.



- В блок нь Хүүхэд хөгжлийн төвөөс тусгаарлах хэсэгт соронзон цоож бүхий шилэн хаалттай амралтын хэсэгтэй
- Өрөө бүр хүүхдийн эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлсэн
- Хичээл хийх орчин нөхцөл бүрдсэн хичээлийн ширээ, номын тавиуртай
- Байгалийн гэрэлтүүлэг хангалттай тусах цэлгэр уужим цонх, дуу чимээ тусгаарлах хаалга зэргийг төлөвлөсөн
- Өрөөний хана, таазыг угааж цэвэрлэх боломжтой эмульсэн будгаар будах бөгөөд шаардлагатай үед өнгө сэргээхэд урсгал зардал багатай байдгаараа давуу талтай
- Өрөө тасалгааны шалыг шахмал PVC хулдаасаар хийх ба уг хулдаас нь чанар эдэлгээний хувьд ломинат, паркетэн шалнаас үнийн хувьд ижил боловч эдэлгээ удаан, арчилж цэвэрлэхэд хялбар байдлаараа давуу талтай.



С блок: 9-өөс дээш насны хөвгүүдэд зориулсан 10 өрөө

ОЛОН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАГДАХ ЗАГВАР ДОТУУР БАЙР-ны **С блокыг** 9-өөс дээш насны Хөвгүүдэд зориулсан 2 төрлийн 10 өрөөтэй байхаар төлөвлөсөн.



- С блок нь Хүүхэд хөгжлийн төвөөс тусгаарлах хэсэгт соронзон цоож бүхий шилэн хаалттай амралтын хэсэгтэй
- Өрөө бүр хүүхдийн эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлсэн
- Хичээл хийх орчин нөхцөл бүрдсэн хичээлийн ширээ, номын тавиуртай
- Байгалийн гэрэлтүүлэг хангалттай тусах цэлгэр уужим цонх, дуу чимээ тусгаарлах хаалга зэргийг төлөвлөсөн
- Өрөөний хана, таазыг угааж цэвэрлэх боломжтой эмульсэн будгаар будах бөгөөд шаардлагатай үед өнгө сэргээхэд урсгал зардал багатай байдгаараа давуу талтай
- Өрөө тасалгааны шалыг шахмал PVC хулдаасаар хийх ба уг хулдаас нь чанар эдэлгээний хувьд ломинат, паркетэн шалнаас үнийн хувьд ижил боловч эдэлгээ удаан, арчилж цэвэрлэхэд хялбар байдлаараа давуу талтай.



D блок: Хөгжлийн бэрхшээлтэй болон бусад тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан 1-2 ортой 14 өрөө

ОЛОН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАГДАХ ЗАГВАР ДОТУУР БАЙР-ны D блокыг Хөгжлийн бэрхшээлтэй болон бусад тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулан 2 төрлийн 14 өрөөтэй байхаар төлөвлөсөн.



- D блок нь Хүүхэд хөгжлийн төвөөс тусгаарлах хэсэгт соронзон цоож бүхий шилэн хаалттай амралтын хэсэгтэй
- D блокыг ашиглах хүүхдүүдийн онцлогоос шалтгаалан өрөө бүр дотроо ариун цэврийн өрөөтэйгөөс гадна нэгдсэн байдлаар хувцас хэрэглэлийн угаалгатай
- Байгалийн гэрэлтүүлэг хангалттай тусах цэлгэр уужим цонх, дуу чимээ тусгаарлах хаалга зэргийг төлөвлөсөн
- Өрөөний хана, таазыг угааж цэвэрлэх боломжтой эмульсэн будгаар будах бөгөөд шаардлагатай үед өнгө сэргээхэд урсгал зардал багатай байдгаараа давуу талтай
- Өрөө тасалгааны шалыг шахмал PVC хулдаасаар хийх ба уг хулдаас нь чанар эдэлгээний хувьд ломинат, паркетэн шалнаас үнийн хувьд ижил боловч эдэлгээ удаан, арчилж цэвэрлэхэд хялбар байдлаараа давуу талтай.



АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨ, ШҮРШҮҮР

ОЛОН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАГДАХ ЗАГВАР ДОТУУР БАЙР-ны В болон С блок тус бүр ариун цэврийн өрөө, шүршүүртэй байхаар төлөвлөсөн.


- Блок тус бүр нэг блокт байрах 48 хүүхдэд хангалттай хүрэлцэхээр норм дүрмийн дагуу төлөвлөгдсөн.
- Ариун цэврийн өрөө, душ нь гэрэлтүүлэг, салхивч, агаар сэлгэлтийг норм дүрмийн дагуу төлөвлөсөн бөгөөд цонхтой тул илүү давуу талтай.
- Ариун цэврийн өрөө, шүршүүрний тоноглолуудыг усны хэмнэлттэй, мэдрэгчтэй тоноглолууд сонгосоноор усны хэрэглээг 20% хүртэл бууруулах боломжтой
- Шүршүүрийн хэсэгт хэрэгцээт алчуур хувцасаа хийх шүүгээ бүхий хувцас солих хэсэгтэй
- Өрөөний таазыг ус чийгэнд тэсвэртэй угааж цэвэрлэх боломжтой лампираар хийх бөгөөд шаардлагатай үед хэсэгчлэн солих боломжтой учир урсгал зардал хэмнэнэ
- Өрөө тасалгааны хана, шалыг шахмал керамик плитагаар хийснээр эдэлгээ удаан, арчилж цэвэрлэхэд хялбар давуу талтай.



**ОЛОН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАГДАХ 150 ХҮҮХДИЙН ХҮЧИН ЧАДАЛТАЙ
ЗАГВАР ДОТУУР БАЙРНЫ БАРИЛГА УГСРАЛТЫН УРДЧИЛСАН ТӨСӨВ**

Д/д	Барилгын нэр	Төсөвт өртөг
1	Гол орц: ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТӨВ	437,430,000
2	Олон зориулалтаар ашиглагдах Урлаг, спортын танхим	271,180,000
3	Нэг ээлжиндээ 00 хүүхдийн хүчин чадалтай цайны газар	280,560,000
4	А жигүүр: 6-8 настай хүүхдийн асран хамгаалагчдад зориулсан гэр бүлийн 8 өрөө	240,140,000
5	В жигүүр: Охидын 10 өрөө	248,920,000
6	С жигүүр Хөвгүүдийн 10 өрөө	248,920,000
7	Д жигүүр: Хөгжлийн бэрхшээлтэй болон бусад тусгай хэрэгцээт хүүхэд байрлах 1-2 ортой 14 өрөө	268,010,000
	ТӨСӨВТ ӨРТӨГИЙН ДҮН	1,995,160,000


- Олон зориулалтаар ашиглагдах 150 хүүхдийн хүчин чадалтай загвар дотуур байрны барилга угсралтын ажлын урдчилсан төсвийг, зураг төслийн “Шифт” ХХК-д боловсруулсан эх загвар зургийн дагуу ажлын тоо хэмжээг үндэслэн Estimator-Pro” программаар тооцов.
- Монгол улсын барилга хот байгуулалтын сайдын 2006 оны 142 дугаар тушаалаар батлагдсан “Барилга сантехникийн ажлын төсвийн суурь норм”-ын үнэлгээ, Зам тээвэр барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалаар батлагдсан барилгын төсөв зохих /БНБД 81-112-12/ дүрмийг үндэслэн төсвийг боловсруулав.
- БНБД 81-01,06,07,08,11,12,13,15,24-06, БНБД 81-16,17,18,19-06, БНБД 81-20,30,38,39,40-04 төсвийн суурь норм болон хавсралтууд, цалин, нэмэгдэл зардлыг ЗТБХБ-ын сайдын 2010 оны 263-р тушаалыг үндэслэв.




ДОТУУР БАЙР НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ОЛЖ БОЛОХ ОРЛОГЫН ТООЦОО

№	Арга хэмжээний төрөл	Хэмжих нэгж	Үнэ	Сараар	Нийт (жил)	Тайлбар
1	Биеийн тамирын заал түрээслэх	цаг	5,000	9	720,000	Орон нутгийн иргэдэд оройн цагаар залыг түрээслэж сургуулийн дотуур байр тодорхой хэмжээний орлого олох боломжтой. Энэхүү тооцоог байгууллага албан газартай гэрээ хийж 7 хоногт нийт 2 удаа өдөрт 2 цагаар 5,000 төгрөгөөр түрээслэнэ гэж тооцов.
2	Кино үзвэр	удаа	30,000	12	360,000	Биен тамирын заалны танхимыг мөн кино үзвэрийн байгууллага-д түрээслэн нэмэлт орлого олох боломжтой байна. Энд 1 кино үзүүлэхэд 30,000 төг олох ба сард 1 удаа кинл үзүүлж нийт 360,000 төг олох боломжтой хэмээн тооцов.
3	Тэмдэглэлт арга хэмжээний залны түрээс	удаа	30,000	3	3,000,000	Хүүхдийн хоолны залыг зуны улиралд хурим найр, хүүхдийн үсний дайх үргээх гэх мэт бусад тэмдэглэлт арга хэмжээнд түрээслэн ашиглах боломжтой байна. Энд мөн 1 арга хэмжээг зохион байгуулахад цагийн 30,000 төгрөг байхаар нийт 20 арга хэмжээ зохион байгуулна гэж тооцов. Нэг арга хэмжээ 3-6 цаг үргэлжилнэ гэж тооцов.
4	Гэр бүлийн өрөөний түрээс	өрөө	10,000	12	2,500,000	Нийт 8 өрөө буюу 16 ортой байх ба хичээлийн саруудад хүүхдийн эцэг эхчүүд хоногийн 10,000 өөр байрлах боломжтой юм. Харин зуны улиралд энэхүү өрөөнд жуулчдыг хүлээн авж дотуур байр нэмэлт орлого олох боломжтой. Эцэг эхчүүдийн байрлах зардлаас гадна, зуны улиралд жуулчдаас бүхэн хүчин чадлаараа ажиллавал 7,2 сая төгрөг олох боломжтой хэдий ч нийт хүчин чадлынхаа дөнгөж 30%-ийг ашиглахад 2,2 сая төгрөг олох боломжтой байна. Иймээс эцэг эхчүүдээс жилд 30 хүүхлийн эцэг эх ирж байрлана гэж тооцвол ойролцоогоор 300,000 төгрөг төвлөрөх боломжтой, үүнээс нэг хичээлийн жилд ойролцоогоор 2,5 сая төгрөг зөвхөн ор хоногийн мөнгөнөөс олох боломжтой юм.
5	Хоолны залын үйлчилгээний түрээс	хүн	10,000	12	2,000,000	Хоолны заал нийт 150 хүний хүчин чадалтай бөгөөд явуулын жуулчдаас болон байранд буусан эцэг эхчүүдэд хоолоор үйлчлэн орлого олох боломжтой бөгөөд мөн бусад тэмдэглэлт арга хэмжээ, баяр ёслолын үеэр захилага ойролцоогоор жилийн турш 2,0 сая төгрөг олох боломжтой юм.
					8,580,000.00	

Жич: Спорт, соёл урлагын арга хэмжээ, үзэсгэлэн яармаг зэрэг арга хэмжээг үнэгүй зохион байгуулна гэж үзсэн тул орлого олох тооцоонд оруулаагүй болно.



Хоёрдугаар давхрын байгуулалт
Масштаб М1:200 @А3



Олон зориулалтаар ашиглагдах
ЗАГВАР ДОТУУР БАЙР
Наг маягийн зураг төсөл
"Шифт" ХХК-ний захирал
Архитектор

Нэр
Г. Ганбаатар
С. Бархас

Гарын үсэг

Эскиз
М1:50
Хуудас 03



ХОЛБОО БАРИХ

**ХАЯГ: УЛААНБААТАР ХОТ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ,
1-Р ХОРОО, АРИЗОНА ТӨВИЙН 4 ДАВХАР**

УТАС: 976-11-329365, ФАКС: 976-11-329365

www.savethechildren.mn

mongolia.secretary@savethechildren.org